



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 06 сарын 19 өдөр

Дугаар А/232

Хэрлэн сум

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, түүнтэй уялдуулан хэрэгжүүлж буй дэд хөтөлбөрүүд, аймгийн хэмжээнд хийж байгаа бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, гадаад харилцаа, орон нутгийн нийгэм эдийн засгийн өнөөгийн байдлыг хөдөө орон нутгийн иргэдэд ил тод мэдээлэх зорилгоор 50 минутын нэвтрүүлэг хийлгэх зардалд 1.000.000 /нэг сая/ төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Нэвтрүүлгийг хийлгэхэд шаардагдах хөрөнгийг Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д, гүйцэтгэлийг зохион байгуулж хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

БАТЛАВ:  
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ДАРГА Ж.ГАНБААТАР

## АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

Хэрлэн сум

2017.05.01

Энэхүү гэрээг нэг талаас Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газар түүнийг төлөөлж Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга Ж.Гантулга /цаашид захиалагч гэх./ нөгөө талаас “Эм Юү Би интертайнмент” ХХК түүнийг төлөөлж захирал Ө.Цолмон /цаашид гүйцэтгэгч гэх./ бид дараах ажлыг гүйцэтгэх чиглэлээр Захиргааны ерөнхий хууль, Иргэний хуулийн дагуу харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

### 1. Нийтлэг үндэслэл

- 1.1. Захиалагч талаас аймгийн Засаг даргын 2016-2020 үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд 2017 оны эхний хагас жилд хийж, хэрэгжүүлсэн ажлын талаар 50 минутын нэвтрүүлэг бэлтгүүлэх
- 1.2. Гүйцэтгэгч тал энэхүү нэвтрүүлгийг 2017 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн дотор бүтээн захиалагч талд хүлээлгэн өгөх.

### 2. Захиалагч талын хүлээх эрх, үүрэг

- 2.1. Захиалагч тал нь гүйцэтгэгч талын нэвтрүүлгийн утга, агуулгад хяналт тавих, бэлэн болох буюу хугацааг тодорхойлох эрхтэй.
- 2.2. Гүйцэтгэгч талыг нэвтрүүлэг бэлтгэхтэй холбоотой материал, эх суравлж, гарын авлагаар хангах, тодорхой албан тушаалтан, мэргэжилтэнтэй холбох, мэдээллээр хангах үүрэгтэй.
- 2.3. Гэрээний үндсэн төлбөр болох 1000000 төгрөг /Нэг сая төгрөг/-ийг гүйцэтгэгч талын дансанд нэвтрүүлгийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 хоногийн өдрийн дотор шилжүүлэх үүрэгтэй.

### 3. Гүйцэтгэгч талын хүлээх эрх, үүрэг

- 3.1. Гүйцэтгэгч нь захиалагч талын өгсөн мэдээлэлийн дагуу нэвтрүүлгийг заасан хугацаанд бэлэн болгох үүрэг хүлээнэ.
- 3.2. Нэвтрүүлгийн зохиол, хийгдэх хугацааг нарийвчлан гаргаж захиалагч талд танилцуулах үүрэгтэй.



3.3 Гүйцэтгэгч тал нь захиалагч талаас өгсөн мэдээллийг гадагш задруулах, өөр зорилгоор ашиглах, бусдад зөвшөөрөлгүй тараахыг хориглоно.

3.4 Гүйцэтгэгч талын хийсэн нэвтрүүлэг захиалагч талын шаардлага, сонирхолд бүрэн нийцсэн байна.

3.5 Гүйцэтгэгч талын хийсэн нэвтрүүлэг, мэдээлэл үнэн зөв байх бөгөөд энэ талаар шаардлагатай мэдээ, материалыг захиалагч талаас нэхэх, холбогдох албан тушаалтантай холбож өгөхийг шаардах эрхтэй.

## 6. Маргааныг шийдвэрлэх.

6.1. Хэрэв маргаантай асуудлаар Талууд тохиролцоонд хүрч чадахгүй тохиолдолд аливаа маргаантай асуудлыг Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

## 7. Бусад заалт

7.1. Талууд үйл ажиллагаандаа Монгол Улсын Иргэний хууль, харилцаа холбооны тухай хууль, бусад хууль тогтоомжийг удирдлага болгоно.

7.2. Гүйцэтгэгч тал заагдсан ажил, үйлчилгээ дууссан талаархи тайланг ажлын гүйцэтгэлийн хамтаар бичгээр тайлан гаргаж захиалагч талд тайлагнана

## 8. Гэрээ хүчин төгөлдөр байх

8.1. Талууд гэрээнд гарын үсэг зурсан үеэс гэрээ хүчин төгөлдөр болно.

8.2. Гэрээ хүчин төгөлдөр болсоноос хойш ажлын 3 хоногт багтаан гэрээний үндсэн төлбөр болох 1000000 төгрөг /Нэг сая төгрөг/-ийг захиалагч талын Хаан банкин дахь 5954379858 тоот дансанд шилжүүлнэ.

8.3. Талууд тохиролцвол гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

## 9. Талуудын хаяг:

Захиалагч тал:

Овог, нэр: Жаргал Гантулга

/Хэнтий аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-ын/

Утас: 98324004

Гарын үсэг:



Гүйцэтгэгч тал:

Овог, нэр: Өлзийхутаг Цолмон

/Эм Юү Би интертайнмент ХХК дарга захирал/

Утас: 91101329

Гарын үсэг: